

**“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ-ЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 06 сарын 14-ний өдөр

Дугаар10

“ГТХЗНТ” УТУГ

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулж удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “ГТХЗНТ” УТУГ-ЫН захирлын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалыг баримтлав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын албан даалгавар, захирлын тушаал, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжүүдийн сарын ажлын төлөвлөгөө, нийтийн мэдээллийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт, туслах чанараар баталсан төлөвлөгөө гэсэн хяналт тавьж биелэлтийг гаргах шаардлага бүхий 10 үзүүлэлтээр 81 баримт бичигт туссан 545 арга хэмжээг хамруулж дүгнэлээ.

Гурав. Үнэлгээ

3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 33 арга хэмжээний хэрэгжилтийг доорх хүснэгтээр үзүүлэв.

| Нэгжийн нэр | Нийт арга хэмжээ | Үүнээс | | | | | | | Биелэлт (хувиар) |
|--|------------------|--------|-----|-----|-----|-----|----|----|------------------|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | ХБ | |
| Захиргаа, санхүүгийн хэлтэс | 8 | 4 | 1 | 2 | 1 | - | - | - | 85.0 |
| Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс | 16 | 10 | 1 | 3 | - | 2 | - | - | 85.0 |
| Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс | 6 | 4 | - | 1 | - | 1 | - | - | 83.3 |
| Нэгжүүд хамtran | 3 | 2 | - | - | - | - | - | 1 | 100 |
| Дүн | 33 | 20 | 2 | 6 | 1 | 3 | - | 1 | 85.6 |

Төсвийн ерөнхийлөн захирагч хянаж, төсвийн шууд захирагч баталсан хөдөлгөөн зохицуулалтын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 6 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 100%-ийн биелэлттэй 20, 90%-ийн биелэлттэй 2,

70%-ийн хэрэгжилттэй 6, 50%-ийн хэрэгжилттэй 1, 30%-ийн хэрэгжилттэй 3, хугацаа болоогүй 1 арга хэмжээтэй, хэрэгжилт дундажаар 85.6%-тай байна.

Биелэлт хангалтгүй үнэлэгдсэн 4 арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-ийн үнэлгээтэй 3 арга хэмжээ:

| | |
|---|---|
| 1 | <p>3.Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох ээлжит зөвлөгөөн зохион байгуулах</p> <p>II улирал: Өмнөх жилийн зөвлөгөөний шийдвэрийн протоколын хэрэгжилтийн тайлан боловсруулж, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналын хамт ЗТХЯ-нд танилцуулж, тухайн жилийн зөвлөгөөнд баримтлах удирдамжийг ЗТХЯ-аар хянуулж батлуулсан байна.</p> <p>Хэрэгжилт: Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцсон 2023.11.28-ны өдрийн зөвлөгөөний протоколын биелэлтийг 2024 оны эхний 5 сарын байдлаар ирүүлэхийг “УБТЗ” ХНН, “МТЛ” ХХК, “МТЛож” ХХК, “ТТЗ” ХХК, “МТЗ” ТӨХК-д 2024.05.17-ны 425, 426, 427, 428, 429 дугаартай албан бичгээр мэдэгдэж “ТТЗ” ХХК 2024.06.12-ны өдөр цахимаар, “МТЗ” ТӨХК 2024.06.12-ны 01/06-1057 дугаартай бичгээр хариу ирүүлээд байна. Зөвлөгөөний протоколын 5.15, “Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ын 2.2, 2.3-т заасны дагуу зөвлөгөөн зохион байгуулах болон бэлтгэл ажлыг хангах асуудлаар “УБТЗ” ХНН-т уулзалт хийх саналыг 2024.05.17-ны 432, ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т зөвлөгөөний удирдамжийг батлуулахаар 2024.06.12-ны 481 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2 12.Төмөр замын тээвэрт цахим гэрчилгээ /RFID/-г нэвтрүүлж, хяналтыг хэрэгжүүлэх</p> <p>II улирал: RFID-ыг бүх вагонуудад суурилуулж, бүртгэлийг хийсэн, гэрчилгээжүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилт: Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх суурь судалгаа, БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх RFID системийн ерөнхий загвар, судалгаа, БНХАУ-д ашиглагдаж буй RFID систем болон авто тээврийн салбарт ашиглагдаж буй “Цахим гэрчилгээ RFID шошго, уншигч суурилуулах” системийн ТЭЗҮ, суурилалтын зураг төсөл, архитектурын бүтэц зэрэг ашиглалтын судалгаа хийж ЗТХЯ-нд 2024.02.14-ний 95 дугаартай албан бичгээр хөдлөх бүрэлдэхүүнд RFID шошго суурилуулах, шаардлагатай цэгүүдийг RFID уншигч бүхий иж бүрэн нэгжээр тоноглох шийдэл бүхий төлөвлөгөө, шаардагдах төсвийг танилцуулсан.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдад 2024.02.16-ны өдөр “Чиглэл хүсэх тухай” 112 дугаартай албан бичгээр БНХАУ-ын Харбины төмөр замын судалгааны институтийн RFID шошго /TAG/, БНСУ-ын КОЙКА-гийн RFID шошго /TAG/ суурилуулахад шаардлагатай зардлын харьцуулалт болон КОЙКА-гаас ирүүлсэн албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>Төмөр замын тээврийн салбарт хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах RFID хяналтын систем нэвтрүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага (ажлын даалгавар) боловсруулж 2024.03.28-ны 242, суурь бүтцүүдийн техникийн тодорхойлолт, RFID давтамжийн зурvas хуваарилалт, RFID технологийн төрөл, RFID уншигч нэгж суурилуулах тулгуур өртөө, зөрleg, RFID шошго суурилуулах хөдлөх бүрэлдэхүүн, технологи нутагшуулах үе шат, шошгод агуулагдах вагоны өгөгдөл, VIS-RFID системийн техникийн үзүүлэлт, давтамжийг таних системийн стандартууд, хүрээлэн буй болон цахилгаан соронзон орчин, радио давтамж, зурvasын өргөний хуваарилалтын, мэдээллийн аюулгүй байдлын судалгаа, RFID нэвтрүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажил, судалгааны тайлангийн дүгнэлтийг ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т 2024.05.31-ний 458 дугаартай албан бичгээр танилцуулсан.</p> <p>3 20.TP TC 001/2011 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын техникийн стандартыг орчуулан боловсруулах</p> <p>II улирал: ЗТХЯ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК, “МТЛ” ХХК, ТЗДС, ТББ-аас санал авсан байна.</p> |
| 2 | |
| 3 | |

Хэрэгжилт: "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын тухай" Гаалийн холбооны техникийн зохицуулалт" (ТР ТС 001/2011) стандартын төслийг шинээр боловсруулж ТЗДС, "Шивээхүрэнгийн төмөр зам" ХХК, "Нарийнсухайтын төмөр зам" ХХК, "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн холбоо" ТББ, "МТЛ" ХХК, "МТЛож" ХХК, "ТТЗ" ХХК, "УБТЗ" ХНН, "МТЗ" ТӨХК, ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-аас санал авахаар 2024.05.24-ний 438, 439, 440, 441, 442, 443, 444, 445, 446, 447 дугаартай албан бичгээр хургуулсанээс ТЗДС-иас 2024.06.06-ны 47/290 дугаартай албан бичгээр санал ирүүлээд байна.

"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50%-ийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

| | |
|---|---|
| 1 | 23.Төвийн архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах II улирал: Архивын баримтад тоо бүртгэл хөтөлж, эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлэх тооллого зохион байгуулж дүн мэдээ гаргасан байна. Хэрэгжилт: "ГТХЗНТ" УТҮГ-ын захирлын 2024.02.23-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Баримт нягтлан шалгах комиссын дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж ХЗДХ-ийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам", хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төвийн архивт 8994 хуудас 47 боть (хадгаламжийн нэгж), 6332.1 MB багтаамжтай баримтыг цахимаар хүлээж авсан. Архивын баримтын тооллого зохион байгуулж байна. |
|---|---|

3.2.Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгаврын хэрэгжилт:

| Сайдын албан даалгавар | Заалтын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Биелэлт /хувь/ |
|--|-------------|------------------------------|----|----|---|----------------|
| | | 100 | 70 | 30 | 0 | |
| Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.02.01-ний өдрийн "Бусчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил" болгон зарлах тухай" 01 дүгээр албан даалгавар | 7 | 4 | 2 | 1 | - | 81.4 |

"Хэрэгжилт хангалтгүй" 30%-ийн хэрэгжилттэй 1 заалт:

| № | Хэрэгжүүлэх заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | 2.10.Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллах орчин нөхцөл, шинэ техник, технологи, инновацын шийдлийг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх; | "ГТХЗНТ" УТҮГ-ын 2024 оны төсөвт ажлын байрны түрээсийн зардалд 66 сая төгрөг батлагдсан. Ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, батлагдсан төсөвт баатаж түрээсийн төлбөр зарцуулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.1.2-т заасны дагуу харьцуулалтын аргаар тендер зохион байгуулж 2024.04.16-ны өдөр тендерийг нээсэн. Тендерт ямарваа нэгэн хуулийн этгээд материал ирүүлээгүй ба тендер амжилтгүй болсон. Ачааны галт тэрэг хоорондын замд аялах явцад үүсэх чичиргээний зонхилох давтамжийг тодорхойлж тус давтамжид үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдлын бичил мэдрэгч, системүүдийг тэжээх боломжийн судалгаа, туршилтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан. |

3.3.Сайдын тушаалын биелэлт:

| Тушаалын тоо | Заалтын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | Биелэлт /хувь/ |
|--------------|-------------|------------------------------|----|----|---|------------------|-----------------|----------------|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | |
| 14 | 26 | 20 | 3 | 2 | - | 1 | - | 90.8 |

“Хэрэгжилт хангалтгүй” 30%-ийн хэрэгжилттэй 2 заалт:

| № | Хэрэгжүүлэх заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | <p>Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2019.07.26 №253</p> <p>1.5. Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгalt авч, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дурэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлог тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дадлыг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх;</p> | <p>2024.05.31-ний өдрийн байдлаар гамшигийн үеийн дутут дохиогоор ажиллах зааварчилгаа-1, томилолтын үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа-4, хариуцлагатай жижүүрээр ажиллах үеийн зааварчилгаа-2 удаа, баяр ёслолын үеийн урьдчилсан зааварчилгаа-3 удаа, үер, усны үеийн зааварчилгаа-3 удаа тус тус өгсөн.</p> |
| 2 | <p>2022.03.09 №A/50 Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай</p> <p>1.2 Зам, тээврийн салбараас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг хөнгөвчилж "И-Монголия" цахим үйлчилгээний нэгдсэн порталд нэвтрүүлэх</p> | <p>Өмчлөгчийн код болон хөдлөх бүрэлдэхүүний дугаар авах үйлчилгээг И-Монголия системд нэвтрүүлэх эрэлт хэрэгцээ, технологийн боломж нөхцөлийн талаар цахим хөгжил, харилцаа холбооны яам "И-Монгол Академи"-ийн Төслийн менежер, систем хөгжүүлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Мягмарсүрэн, холбогдох мэргэжилтэнтэй уулзалт хийж санал солилцсон. И-Монголия төрийн цахим үйлчилгээний системд үйлчилгээг бүртгүүлэх нь одоогоор шаардлагагүй ба зам тээврийн салбарын нэгдсэн платформд хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн модуль хөгжүүлэлтийн ажлыг харгалзан үзэж, цаашид иргэдэд хэрхэн үйлчлэх талаар судласны үндсэн дээр нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн өгсөн санал зөвлөмжийн дагуу зам тээврийн салбарын нэгдсэн платформ дээр үүсгэсэн бүртгэлийн модулийг хөдлөх бүрэлдэхүүний дугаар бүртгэлийн цахим систем байдлаар хөгжүүлсэний дараа нь И-Монголия төрийн үйлчилгээний системтэй холбож ашиглахаар төлөвлөөд байна. Салбарын нэгдсэн платформыг олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд ГТХЗНТ-өөс оруулж байгаа хөдлөх бүрэлдэхүүн, гол болон салбар замын бүртгэлд тус бурийн өгөгдлийг тухай бүр оруулах баяжуулах ажлыг гүйцэтгэж байна. Гэрчилгээ олгогдсон дагнасан хэрэглээний 388 салбар зам, 12501 хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийг СНП-д байршуулсан. Ачаа тээврийн статистик мэдээ (маягт №9б)-ний бүтэц үүсгэн суурь бүтэц эзэмшигч компаниудад мэдээллээ оруулах боломжтой болгосон. Төвийн холбогдох мэргэжилтэн 2023.09.07-08-ны өдөр 3ТХЯ дээр ажиллаж СНП дээрх төмөр замын тээврийн статистик үзүүлэлтүүдийн чарт, дашбоардуудыг</p> |

| | | |
|--|--|--|
| | | цэгцлэх, нэг ижил загвараар дүрслэн харуулах ажлыг гүйцэтгэж байна. Хөдлөх бүрэлдэхүүний дугаар олгох, баталгаажуулах цахим системийг "И-Монголиа" төрийн цахим үйлчилгээний нэгдсэн порталд сууринж хөгжүүлэх боломж нөхцөл, холбох талаар "И-Монгол Академи" УТУГ-тай хамтран ажиллах чиглэлээр судалгаа хийж байна. |
|--|--|--|

3.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт:

| Тушаалын тоо | Заалтын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | Биелэлт /хувь/ |
|--------------|-------------|------------------------------|----|----|---|------------------|-----------------|----------------|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | |
| 2 | 2 | 2 | - | - | - | - | - | 100 |

3.5. Захирлын тушаалын хэрэгжилт:

| Тушаалын тоо | Заалтын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | Биелэлт /хувь/ |
|--------------|-------------|------------------------------|----|----|---|------------------|-----------------|----------------|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | |
| 36 | 48 | 32 | 7 | - | 2 | 2 | 4 | 90.0 |

"Хэрэгжээгүй" 0%-ийн хэрэгжилттэй 2 заалт:

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | д/д | Хэрэгжүүлэх заалт | | | | | | | |
|---|---|-----|---|--|--|--|--|--|--|--|
| | | | Хэрэгжүүлэх заалт | | | | | | | |
| 1 | Хариуцлагатай жижүүр томилох тухай 2024.02.02 Дугаар A/05 | 4. | 3.Хариуцлагатай жижүүр томилж ажиллуулсан тухай тайланг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст үүрэг болгосугай. | | | | | | | |
| 2 | Томилолтоор ажиллуулах тухай 2024.05.06 Дугаар A/27 | 2. | 2.Томилолтоор ажилласан тайланг ажлын 3 хоногт багтаан танилцуулахыг ахлах мэргэжилтэн /Д.Бат-Оргил/-д үүрэг болгосугай. | | | | | | | |

3.6. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

| Нэгжийн нэр | Нийт арга хэмжээ | Үүнээс | | | | | | | Биелэлт (хувиар) |
|-----------------------------|------------------|--------|-----|-----|-----|-----|----|----|------------------|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | ХБ | |
| Захиргаа, санхүүгийн хэлтэс | 43 | 22 | 7 | 3 | 2 | 1 | 4 | 4 | 81.3 |

Биелэлт хангальгүй үнэлэгдсэн 7 арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

"Үр дүнгүй" буюу 0%-ийн үнэлгээтэй 4 арга хэмжээ:

| | |
|---|---|
| 1 | 9.Төвийн архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах II улирал: Архивын баримтад тоо бүртгэл хөтөлж, эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлэх тооллого зохион байгуулж дун мэдээ гаргасан байна. |
| 2 | 16.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг төмөр замын газрын хүний нөөцийн төлөвлөлт, эрэлт хэрэгцээний судалгаа хийх Хагас жилийн байдлаар: ЗТХЯ-нд танилцуулсан байна. |
| 3 | 19.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын мэдлэгийн түвшин тогтоо шалгалт зохион байгуулж үр дүнг мэдээлэх |

| | |
|---|---|
| | Хагас жилийн байдлаар: Шалгалтыг 1 удаа зохион байгуулж үр дүнг танилцуулсан байна. |
| 4 | <p>21. Захирлын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах, тэмдэглэл, үүрэг даалгаврыг хөтлөх, нэгж ажилтанд шуурхай хүргэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах</p> <p>Тухай бүр: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгавар, гүйцэтгэлийн төлөвлөгөө, бусад цаг үеийн асуудлыг хэлэлцэж, явцын мэдээллийг сонсож, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажилласан байна.</p> |

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-ийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

| | |
|---|---|
| 1 | <p>40. Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах</p> <p>II улирал: Хууль хэрэгжүүлэхтэй холбоотой бүтэц, зохион байгуулалт, санхүү хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө, хүний нөөц, эрхэүйн баримт бичгүүдийн төслийг төлөвлөн боловсруулж, батлахад бэлэн болгоно.</p> <p>Хэрэгжилт: ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-ын 2024.05.06-ны өдрийн 08/1982 дугаартай албан бичгээр Төмөр замын тээврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ирүүлсэн. Хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан хэрэгжүүлэх 24 арга хэмжээ бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж удирдлагад танилцуулсан.</p> |
|---|---|

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50%-ийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:

| | |
|---|---|
| 1 | <p>13. Албан тушаалын тодорхойлолтыг батлуулах</p> <p>I улирал: Албан тушаалын 24 тодорхойлолт батлагдсан байна.</p> <p>Хэрэгжилт: Албан тушаалын тодорхойлолтын 25 төслийг боловсруулж 2024.03.13-ны өдөр эйбл системийн бичиг төлөвлөлт модулиар шилжүүлж, олон нийтийн хэлэлцүүлэгт байршуулж ГХБАБМХ, ТНУАСХ-ийн даргын саналыг тусгаж хянуулсан. Төслүүд ЗСХ-ийн даргын албан үүргийг хавсралтад гүйцэтгэгчээр хянагдаж байна.</p> |
| 2 | <p>29. Төвийн хэмжээнд дотоодын хяналтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах</p> <p>Тухай бүр: Зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байхад дэмжлэг үзүүлж зөвлөмж өгсөн байна.</p> <p>Хэрэгжилт: Ажилтнуудын 1, 2, 3, 4, 5 дугаар сарын цагийн бүртгэлд дүн шинжилгээ хийж “ГТХЗНТ” УТҮГ-ын захиралд тайланг 2024.02.13, 2024.03.07, 2024.04.17, 2024.05.29, 2024.06.07-ны өдөр танилцуулсан. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлэх 2024.03.06-ны 149 (Гүйцэтгэлийн тайлан), ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлэх 2024.03.06-ны 150 (2-р сарын зурмагийн тасалдлын тайлан) дугаартай албан бичгийн хавсралтууд солигдож ЗТХЯ-нд хүргэгдсэнийг засуулав.</p> |

3.7. Нэгжийн сарын төлөвлөгөөний хэрэгжилт:

| Cap | Нийт | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | | | | Биелэлт |
|------------------------------------|------|------------------------------|----|----|----|----|---|----|---------|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | ХБ | |
| Захиргаа, санхүүгийн хэлтэс | | | | | | | | | |
| 1 cap | 9 | 7 | 1 | - | 1 | - | - | - | 93.3 |
| 2 cap | 16 | 12 | - | 1 | - | 1 | 2 | - | 81.3 |
| 3 cap | 19 | 11 | - | 3 | 1 | - | 3 | 1 | 75.6 |
| 4 cap | 12 | 6 | 1 | 2 | 1 | 1 | 1 | - | 76.0 |
| 5 cap | 16 | 13 | 1 | 1 | - | - | 1 | - | 91.3 |

| Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс | | | | | | | | | |
|---|----|----|---|---|---|---|---|---|------|
| 1 сар | 16 | 15 | - | - | - | 1 | - | - | 95.6 |
| 2 сар | 26 | 24 | - | - | 1 | - | - | - | 94.2 |
| 3 сар | 20 | 16 | 1 | 2 | - | 1 | - | - | 93.0 |
| 4 сар | 15 | 12 | 1 | 1 | 1 | - | - | - | 94.0 |
| 5 сар | 25 | 22 | - | 3 | - | - | - | - | 96.4 |

| Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бурэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс | | | | | | | | | |
|--|-----|-----|---|----|---|---|---|---|------|
| 1 сар | 6 | 6 | - | - | - | - | - | - | 100 |
| 2 сар | 6 | 6 | - | - | - | - | - | - | 100 |
| 3 сар | 4 | 4 | - | - | - | - | - | - | 100 |
| 4 сар | 4 | 4 | - | - | - | - | - | - | 100 |
| 5 сар | 8 | 7 | 1 | - | - | - | - | - | 98.7 |
| Нийт | 202 | 165 | 6 | 13 | 5 | 4 | 7 | 1 | 91.2 |

3.8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

| Д/Д | Шалгуур үзүүлэлтийн төрөл | Хэрэг жүүлэх үзүүлэлт ийн тоо | Үүнээс /хувиар/ | | | | | Хэрэгжилт ийн дун даж хувь |
|-----|--|-------------------------------|-----------------|----|----|---|------------------|----------------------------|
| | | | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 1 | 8.2 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт | 8 | 5 | 3 | - | - | - | 89.1 |
| 2 | 8.3 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 6 | - | 6 | - | - | - | 88.0 |
| 3 | 8.4 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа | 13 | 8 | 4 | - | - | 1 | 89.8 |
| 4 | 8.5 Үзүүлж байгаа үйлчилгээ | 1 | 1 | - | - | - | - | 92.0 |
| 5 | 8.6 Бусад мэдээлэл | 2 | 1 | - | - | 1 | - | 44.0 |
| Дүн | | 30 | 15 | 13 | - | 1 | 1 | 86.2 |

3.9. Шилэн дансны хөтлөлт:

| № | Мэдээллийн агуулга | Байршуул бал зохих мэдээлэл | Мэдээлэл хугацаандаа оруулсан (хувиар) | Хугацаа хоцроож байршуулсан (хувиар) | | | | Мэдээлэл оруулах хугацаа болоогүй | Дундаж хувь |
|-----|--|-----------------------------|--|--------------------------------------|----|----|---|-----------------------------------|-------------|
| | | | | 100 | 70 | 30 | 0 | | |
| 1 | Төсөв, гүйцэтгэл | 26 | 26 | - | - | - | - | - | 100 |
| 2 | Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт | 17 | 17 | - | - | - | - | - | 100 |
| 3 | Бусад | 25 | 25 | - | - | - | - | - | 100 |
| Дүн | | 68 | 68 | - | - | - | - | - | 100 |

3.10. Туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилт:

| Төлөвлөгөөний нэр | Нийт арга хэмжээ | Үүнээс /хувиар/ | | | | | | | Биелэлт (хувиар) |
|---|------------------|-----------------|----|----|----|----|---|----|------------------|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | ХБ | |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын | 15 | 11 | - | - | - | 1 | 3 | - | 75.3 |

| | | | | | | | | | |
|--|----|----|---|---|---|---|----|----|------|
| Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын | 22 | 8 | 1 | 3 | 4 | 1 | 3 | 2 | 66.1 |
| “Бусчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын | 14 | 6 | 1 | 2 | - | 3 | 1 | 1 | 70.8 |
| Алга таших ажлын | 4 | 2 | - | - | - | 2 | - | - | 65.0 |
| Мод тарих ажлын | 2 | 1 | - | - | - | - | - | 1 | 100 |
| ХАБЭА-н сарын аяны | 5 | 5 | - | - | - | - | - | - | 100 |
| Ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын | 10 | 6 | - | - | - | - | 2 | 2 | 75.0 |
| Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 5 | 1 | - | - | 1 | - | 2 | 1 | 37.5 |
| 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх | 9 | - | - | - | - | - | - | 9 | ХБ |
| Дүн | 86 | 40 | 2 | 5 | 5 | 7 | 11 | 16 | 71.2 |

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дун:

| № | Баримт бичиг | Нийт арга хэмжээ | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | | | Хугацаа болоогүй | Хучингүй болсон | Биелэлт /хувиар/ |
|----------|-------------------------------------|------------------|------------------------------|----|----|----|----|----|------------------|-----------------|------------------|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | | |
| 1. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 33 | 20 | 2 | 6 | 1 | 3 | - | 1 | - | 85.6 |
| 2. | Сайдын албан даалгавар | 7 | 4 | - | 2 | - | 1 | - | - | - | 81.4 |
| 3. | Сайдын тушаал | 26 | 20 | - | 3 | - | 2 | - | 1 | - | 90.8 |
| 4. | ТНБД-ын тушаал | 2 | 2 | - | - | - | - | - | - | - | 100 |
| 5. | Захирлын тушаал | 48 | 32 | - | 7 | - | - | 2 | 2 | 4 | 90 |
| 6. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө | 43 | 22 | 7 | 3 | 2 | 1 | 4 | 4 | - | 81.3 |
| 7. | Нэгжийн сарын төлөвлөгөө | 202 | 165 | 6 | 13 | 5 | 4 | 7 | 1 | - | 91.2 |
| 8. | Нийтийн мэдээллийн ил тод байдал | 30 | 15 | - | 13 | - | - | 1 | 1 | - | 86.2 |
| 9. | Шилэн дансны хөтлөлт | 68 | 68 | - | - | - | - | - | - | - | 100 |
| 10. | Туслах чанараар баталсан төлөвлөгөө | 86 | 40 | 2 | 5 | 5 | 7 | 11 | 16 | - | 71.2 |
| Нийт дүн | | 545 | 388 | 17 | 52 | 13 | 18 | 25 | 26 | 4 | 88.0 |

Тав. Дүгнэлт

1. “ГТХЗНТ” УТҮГ-ын 2024 оны хагас жилийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний 33, сайдын албан даалгаврын 7, сайдын тушаалын 26, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын 2, захирлын тушаалын 48, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 43, нэгжүүдийн сарын төлөвлөгөөний 202, нийтийн мэдээллийн ил тод байдлын 30, шилэн дансны хөтлөлтийн 68, туслах чанараар баталсан төлөвлөгөөний 86, нийт 545 арга хэмжээг хамруулж хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.

2. Хяналт-шинжилгээнд хамрагдсан арга хэмжээнээс биелсэн 405, хэрэгжих шатанд 65, хэрэгжилт хангалтгүй 18, хэрэгжээгүй 25, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 26, хүчингүй болсон 4 арга хэмжээтэй, төвийн үйл ажиллагаа 2024.06.24-ний өдрийн байдлаар 88.0%-ийн биелэлттэй байна.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +5.9%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +7.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +4.0%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +16.6%-иар өссөн үзүүлэлттэй байна.

5. Сайдын албан даалгаврын хэрэгжилтийг тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +22.8%-иар, сайдын тушаалын биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +1.7%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.

6. Захирлын тушаалын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +17.1%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +10.6%-иар өссөн байна.

7. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +7.7%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +6.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

8. Нэгжүүдийн сарын ажлын биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +2.6%-иар өссөн байна.

9. Нийтийн мэдээллийн ил тод байдлын биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -10.5%-иар буурсан, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +7.0%-иар өссөн дүнтэй байна.

10. Туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +3.0%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +20.9%-иар өссөн үзүүлэлттэй байна.

11. Хариутай албан бичиг, өргөдөл хүсэлтийн 92.5%-ийг шийдвэрлэж хариу өгсөн байна. Албан бичгийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -5.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.

12. Төвөөс явуулсан хариутай бичгийн 63.3%-д хариу ирсэн байна. Хариу ирүүлээгүй албан бичгийн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -12.0%-иар буурсан байна.

Зургаа. Санал зөвлөмж

1. Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцсон 2023 оны II зөвлөгөөний протоколын хэрэгжилтийн тайлан боловсруулж, шаардлагатай арга хэмжээний саналын хамт ЗТХЯ-нд танилцуулах, 2024 оны III зөвлөгөөний удирдамжийг батлуулах;

2. “ГТХЗНТ” УТҮГ-ын энтерфрайз архитектурын загвар боловсруулах судалгааны ажлыг эрчимжүүлж үр дүнд хүргэх, албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг ашиглалтыг нэмэгдүүлэх;

3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд аялах ачааны галт тэрэгт STLIS3DH маркийн чичиргээ хэмжих төхөөрөмж суурилуулж туршилт, судалгааны ажил зохион байгуулах;
4. “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын тухай” Гаалийн холбооны техникийн зохицуулалт” (ТРТС 001/2011) стандартын төсөлд төмөр замын байгууллагуудаас санал авах;
5. Архивын баримтын тооплого зохион байгуулж дүн мэдээ гаргах;
6. Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан бэлтгэл ажлын төлөвлөгөөнд туссан ажлуудыг хэрэгжүүлэх;
7. ХАБЭА-н дотоод хяналтын журмыг хэрэгжүүлж ажлын байрны онцлогт тохируулан ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, гарын үсэг зуруулж байх;
8. Нэгжийн гүйцэтгэлийн болон туслах чанараар баталсан төлөвлөгөөнд туссан эрчимжүүлэх шаардлагатай, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй 30 ажлыг бүрэн хэрэгжүүлэх;
9. Сарын ажлын төлөвлөгөөний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, төлөвлөлтийг сайжруулах, нэгжийн удирдлага хяналт тавьж ажиллах;
10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгаж, тухай бүр шинэчилж баяжуулж байх;
11. Өргөдөл хүсэлт, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж албан бичгээр хариу өгөх, төвөөс тодорхой асуудал дэвшүүлж явуулсан хариу авах шаардлагатай бичгийн араас хөөцөлдөж, илгээсэн байгууллага, цохогдсон албан тушаалтнаас бичгийн хариуг лавлах, хариу ирүүлээгүй тохиолдолд дахин бичиг илгээн бичгийн хариуг авах талаар санал санаачлага гаргаж ажиллах.

ТАНИЛЦСАН:

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВ УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН АШИГЛАЛТ,
БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙНДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТЭЭВРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА, АВТОМАТЖУУЛАЛТ,
СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.АЛИМАА

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЗОЛЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОСОРЖАМАА